



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.САЙНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.03.18 № 1а/1299
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны ерөнхий боловсролын сургалтын талаар асуулга хүргүүлэх тухай 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 13 дугаартай Монгол Улсын Их Хурлын гишүүнийн асуулгатай танилцлаа.

Асуулгатай холбоотой дараах мэдээллийг хүргүүлж байна.

Нэг. Ерөнхий боловсролыг эзэмшүүлэх сургалтын хэлбэрийн нэг нь танхимын бус сургалт бөгөөд танхимын бус сургалтад зайн, хувилбарт болон цахим, дадлага сургалт байхаар Боловсролын ерөнхий хуульд хуульчилсан. Танхимын бус сургалт, тэр дундаа дадлага сургалтыг хэрхэн зохион байгуулж байгаа талаарх өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд

Боловсролын ерөнхий хуульд “8.1.Сургалт нь танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрийн зохион байгуулалттай байна”, “8.2.Танхимын бус сургалтад зайн, хувилбарт болон цахим, дадлага сургалт хамаарна” гэж хуульчилсан.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт заасны дагуу ерөнхий боловсролын сургууль нь зайн болон цахим сургалтыг зохион байгуулахаар заасан.

Бүлэг дүүргэлт, багшийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хөдөөгийн сургуулийн ахлах ангийн суралцагчдын дунд үүсдэг бэрхшээлийг арилгах, тэдэнд сонгон судлах хичээлийг судлах тэгш боломж олгох зорилгоор Мэдлэ ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлүүлсэн.

Засгийн газрын 2025 оны 130 дугаар тогтоолоор Технологийн дэвшлийг ашиглан зайн сургалтаар дэлхийн түвшний боловсрол олгох зорилтын хүрээнд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий төрийн өмчийн "Ерөнхий боловсролын цахим сургууль" байгуулсан.

Боловсролын салбарын 2025-2026 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 39.7 хувь нь багшаар бүрэн хангагдсан байна. Энэхүү нөхцөл байдал нь багшийн дутагдал, боловсролын хүртээмж, тэгш бус байдал гэх тулгамдсан асуудлыг үүсгэж байгаа тул дутагдалтай

• 142611079

багшийг нөхөж, мэргэжлийн чадварлаг багш нараар хичээлийг зайн болон цахим сургалтаар хичээллэхэд илүү анхаарч ажиллаж байна.

Хоёр. Стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлага хангасан хэдэн номын сан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, ерөнхий боловсролын сурагчдад зориулсан цахим номын сан бий эсэх, тэдгээрийн үйлчилгээний хүртээмж, төлбөртэй эсэх, номын сангийн баяжилт, шинэчлэл, хөрөнгө оруулалтын тухайд

Номын сангийн тухай хуулийн "10.3.Бүх шатны боловсролын байгууллага сургалтын номын сантай байх бөгөөд сургалтын номын сан нь багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ" гэж, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн "18.12.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь номын сантай байх бөгөөд Номын сангийн тухай хуулийн 10.3-т заасан үйлчилгээ үзүүлнэ" гэж тус тус хуульчилсан.

"Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2019" стандартаар уншлагын танхим, уншлагын танхимын номын санч-мэдээллийн ажилтан, үйлчлүүлэгчид ногдох талбайн хэмжээ, номын сангийн тоног төхөөрөмж зэрэг шаардлагыг стандартчилсан. Тухайлбал, уг стандартын дагуу ерөнхий боловсролын сургуулийн номын санд 500 суралцагч тутам 1-2 номын санч-мэдээллийн ажилтан ажиллахаар туссан.

Энэ хичээлийн жилд улсын хэмжээнд нийт ерөнхий боловсролд 9,762,051 номын фондтой 25,679 суудал бүхий 859 номын сан үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд сургуулийн номын санд 793 номын санч ажиллаж байгаагийн төрийн өмчийн сургуульд 724, төрийн бус өмчийн сургуульд 69 байна. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 717 сургуульд нийт 8,693,194 ном бүхий номын фондтой, 20,096 суудалтай 719 сургуулийн номын сан үйл ажиллагаа явуулж байна.

2025 онд боловсролын сургалтын байгууллагуудад хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийслэл, орон нутгийн ерөнхий боловсролын нийт 322 объектын 51.6 хувь нь номын сангийн үйлчилгээнд цахим үйлчилгээ нэвтрүүлж, зайн болон цахим хичээлийн сан бүрдүүлж, суралцагчид ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлээгүй; 47.3 хувь нь багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан номын сангүй байна. Мөн 40.2 хувь нь Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.12, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/100 дугаар тушаал "ЕБС-ийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 2.2.10 дахь заалт, Номын сангийн орчин нөхцөл үйл ажиллагаанд тавих шаардлага. MNS5742:2019 стандартын хэрэгжилт хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Ерөнхий боловсролын сургуулиудад "Сурах бичгийн цахим бүртгэл, хяналтын систем"-ийг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн нэвтрүүлж, сурах бичгийн захиалга, бүртгэл болон түрээсийн төлбөр тооцооны үйл ажиллагааг бүрэн цахимжуулаад байна. Энэхүү систем нэвтэрснээр сурах бичгийн түрээсийн төлбөр номын санчид бэлнээр төвлөрөх, сургуулийн данснаас зориулалтын санд

шилжихгүй саатах зэрэг санхүүгийн эрсдэлүүдийг арилгасан. Түүнчлэн суралцагчдад очих сурах бичгийн багц дутах, нийлүүлэлтийн тоо зөрөх зэрэг хүндрэлүүд шийдэгдэж, сурах бичгийн хангамж, түгээлтийн үйл ажиллагаанд тавих хяналт бодитойгоор сайжирч байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д “Сурах бичгийг бага ангийн суралцагчид төлбөргүйгээр, дунд, ахлах ангийн суралцагчид сургуулийн номын сангаар дамжуулан төлбөртэй ашиглуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол сурах бичгийг худалдан авч болно” гэж заасан. Худалдан авах хүсэлт гаргаснаар VI-XII ангийн сурах бичгийг анги, багцад багтсан сурах бичгийн тооноос хамаарч 94,000-129,000 төгрөгөөр худалдан авах боломжтой (<https://shop.aplus.mn/t/surakh-bichig>).

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Төлбөрийн хэмжээ тогтоох тухай” А/392 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын ашиглах багц сурах бичгийн төлбөрийн хэмжээг тогтоосон. Тушаалын дагуу улсын төсвийн хөрөнгөөр ерөнхий боловсролын сургуулийн номын сангаар дамжин төлбөртэй ашиглуулж буй түрээсийн сурах бичгийн үнэ 18,000-33,000 төгрөг байна.

Гурав. Ерөнхий боловсролын сургалтад ашиглагдаж буй ном, сурах бичгийн жагсаалт, дахин хэвлэлтийн давтамж, ялгаа /анги тус бүрээр/, тэдгээрийн агуулгыг хэрхэн тогтоож баталгаажуулах үйл явц, ном, сурах бичгийн хүртээмж, хэвлэхэд зарцуулсан хөрөнгө, бага ангийн сурагчдын ашиглаж буй ном, сурах бичгийн тоо, дундаж жингийн тухайд

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд сурах бичиг нь сургалтын хөтөлбөрт нийцсэн байхаар заасан. Сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн боловсруулж, Сургуулийн өмнөх боловсролын болон Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөл, Боловсролын үндэсний зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Боловсролын сайд баталдаг. Мөн хуулийн дагуу Ерөнхий боловсролын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн ерөнхий боловсролын сургалтад хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталдаг.

Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа жагсаалтын дагуу ерөнхий боловсролын сургалтад дараах сурах бичгийг ашиглаж байна. Үүнд: I анги: 8 сурах бичиг, II анги: 7 сурах бичиг, III анги: 7 сурах бичиг, IV анги: 9 сурах бичиг, V анги: 10 сурах бичиг, VI анги: 12 сурах бичиг, VI – VII ангийн 2 сурах бичиг, VII анги: 17 сурах бичиг, VIII анги: 17 сурах бичиг, VIII-IX ангийн 1 сурах бичиг, IX анги: 17 сурах бичиг, X анги 15 сурах бичиг, X-XI ангийн 1 сурах бичиг, XI анги: 15 сурах бичиг, XII анги: 10 сурах бичиг, мөн боловсролын ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан 12 сурах бичиг зэрэг болно.

2024-2025 оны хичээлийн жилд улсын төсвийн 1.4 тэрбум, түрээсийн эргэлтийн сангийн 3.0 тэрбум, нийт 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бага ангийн 25 нэрийн 657.0 мянган ширхэг, дунд, ахлах ангийн 124 нэрийн 74.9 мянган багц буюу 1,2 сая ширхэг сурах бичиг хэвлэгдсэн.

2025-2026 оны хичээлийн жилд бага ангийн 42 нэрийн 1705.4 мянган ширхэг сурах бичиг, дунд, ахлах ангийн 104 нэрийн 54400 багц, 818800 ширхэг сурах бичиг хэвлэсэн.

Өнгөрсөн хичээлийн жилд 351,216 багц сурах бичиг ашиглагдсан нь нийт хүүхдийн 80 хувийг хамарч байна. 2025-2026 оны хичээлийн жилд дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалт 94.0, бага ангийн сурах бичгийн хангалт 100 хувьтай байна.

Цаасан сурах бичгийн хүртээмжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор <https://econtent.edu.mn/> цахим хуудсанд 1-12 дугаар ангийн бүх хичээлийн сурах бичиг буюу 185 төрлийн сурах бичгийг байршуулсан тул цахим хэлбэрээр хэрэглэх боломж бүрдсэн.

Бага ангийн сурах бичгийг интерактив хэлбэрт шилжүүлж 1-5 дугаар ангийн 33 төрлийн сурах бичиг <https://e-sur.edu.mn/> цахим хуудсанд байршуулсан. Интерактив сурах бичиг нь суралцагч бие даан, тодорхой судлагдахууны сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшин, хэрэгцээнд нийцүүлэн дахин давтан судлах, дасгал, даалгаврыг суралцагчид цахим орчинд бие даан гүйцэтгэх, өөрийгөө шалгах, ахиц амжилтаа үнэлэх боломж олгодог.

Энэ хичээлийн жилээс Mozaik education (<https://www.mozaweb.mn>) платформыг 6-12 ангийн төрийн өмчийн сургуулийн бүх багш, сурагчид хэрэглэх боломжтой боллоо. Багшийн хувьд хичээл зохион байгуулах бүх үе шатанд цахим орчныг үр дүнтэй ашиглах, суралцагчийн ахицыг бодит өгөгдлөөр үнэлэх боломжтой болно. Суралцагчийн хувьд хичээлээ илүү ойлгомжтой, сонирхолтойгоор үзэж, бие даан суралцах, өөрийн ахиц дэвшлийг тогтмол харах боломж бүрдэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн ашиглалтын хугацааг дөрвөн жил байхаар тооцдог бөгөөд энэхүү мөчлөгийн дагуу нөхөн хангалтын ажлыг тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал, жил бүр дунд, ахлах ангийн нийт суралцагчдын 20 орчим хувьд шаардлагатай сурах бичгийг улсын төсөвт багтаан шинээр хэвлэж, сургуулиудын хэрэгцээг ханган ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагч ангиасаа хамаарч 7-10 сурах бичгийг ашиглаж байна. Жингийн хувьд нэг ном 250-450 грамм, нийт жин 2.5-3.5 кг байна.

Дөрөв. Сургалтад цахим технологи, хэрэглэгдэхүүнийг ашигладаг эсэх, багш цахим технологийг үр дүнтэй ашиглах арга зүйд суралцахад дэмжлэг үзүүлсэн, хэрэгжүүлсэн арга хэмжээ, цахим сургалт, контент бүтээх, сургалтын нээлттэй нөөц материал болон бусад цахим системийн ашиглалтын тухайд

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Боловсролын багц хуульд анх удаа боловсролын салбарт цахим, зайны сургалттай холбоотой харилцааг хуульчилсан.

Цар тахлын үед цахим сургалтад шилжиж, суралцагчийн сурч боловсрох эрхийг хангаж ажилласныг үнэлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2022 оны Ерөнхий ассамблейн 77 дугаар чуулганы хүрээнд АНУ-ын Нью-Йорк хотноо "Хувьсаж буй боловсрол" дээд хэмжээний чуулга уулзалтаар ЮНЕСКО, НҮБ-ийн

Хүүхдийн Сан хамтарч "Олон нийтийн цахим суралцахуйн гарцууд (Gateways to Public Digital Learning)" санаачилгыг зарлаж, тэргүүлэгч улсын тоонд Монгол Улсыг нэрлэж байсан.

Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан орон нутгийн ахлах ангийн суралцагчдын сонгон судлах хичээлээ судлах тэгш боломж олгох зорилгоор Мэдлэ платформд тулгуурлан ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлүүлсэн. 2025-2026 оны ахлах ангийн 12,326 суралцагч 16 төрлийн судлагдахуунаар 16,587 хичээл сонголт хийж, 764 ангид хуваагдан, 289 багшийн хичээлд хамрагдаж байна. Энэхүү туршлагад үндэслэн Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 130 дугаар тогтоолоор төрийн өмчийн олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий ерөнхий боловсролын анхны цахим сургууль байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлэх бэлтгэлээ хангаж байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд цахим платформд суурилсан олон улсын жишигт нийцсэн цахим хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд англи хэлний хичээл дээр "Pearson" хөтөлбөрийг 2022-2023 оны хичээлийн жилээс, математикийн хичээл дээр "Eduten" хөтөлбөрийг 2023-2024 оны хичээлийн жилээс тус тус хэрэгжүүлж байна.

Энэ ажлын хүрээнд 2025-2026 оны хичээлийн жилийн байдлаар англи хэлний "Pearson" хөтөлбөрийг нийт сургуулийн III-VIII ангид, туршилтаар 38 сургуулийн IX-XII ангид хэрэгжүүлж, нийт 424,319 сурагчийг хамруулж байгаа бол "Eduten" цахим системийг нийт сургуулийн I-VI ангид, сургуулийн сонголтоор VII-IX ангид тус тус хэрэгжүүлж, нийт 700 сургуулийн 510,543 суралцагч хэрэглэж байна.

Мөн 2025-2026 оны хичээлийн жилд нийслэлийн өндөр ачаалалтай сургуулиудыг 3 ээлжид шилжих эрсдэлийг бууруулах зорилгоор нийслэлийн 53 төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд "Хосолсон сургалт"-ыг хэрэгжүүлж эхлээд байна. Хосолсон сургалтаар дунд ангид 3, ахлах ангид заавал судлах 3 судлагдахуун, мөн XI-XII ангийн сонгох судлах хичээлээс тус бүр 1 цаг байхаар сонгосон. Хосолсон сургалтыг хэрэгжүүлснээр 7 хоногт 2,366 бүлгийн 91,935 суралцагч 7,207 хичээлийн цагийг цахимд шилжүүлэн туршилтаар хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч бие даан суралцах, мэдлэг чадвараа бататгах үйлийг дэмжих, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын тасралтгүй байдлыг хангах, багш хичээл, сургалтыг зайнаас зохион байгуулах, дэлхийн өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багшийн бэлтгэсэн цахим хичээлийг суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий MEDLE.MN сургалтын нэгдсэн платформыг боловсруулан, 2019 оноос хэрэгжүүлж байна. Тус платформд тулгуурлан багш бүрийг цахим агуулга боловсруулах боломжоор хангаж, нийлүүлсэн контентын үр дүнгээр нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлсэн юм. Одоогийн байдлаар байдлаар MEDLE контентын санд ээлжит хичээл 11,265, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл нийт 20,000 гаруй контент байршаад байна.

Түүнчлэн 2024 оны 5 дугаар сараас эхлэн БНПУ-ын "Learnetic" компанитай хамтран ерөнхий боловсролын I-V ангийн нийт 33 сурах бичгийг бүрэн дижитал, интерактив болгосон www.sur.esis.edu.mn системийг хөгжүүлсэн. Мөн БНУУ-ын Moziak" компанитай хамтран VI-XII ангийн 100 сурах бичиг, бүх дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт шилжүүлэх ажил хийгдэж байна.

Үүний үр дүнд бага ангийн 1,675 хичээл, 15,864 интерактив хуудас, 12,525 дасгал даалгавар, ахлах, дунд ангийн 800+ 3D үзүүлэн, 243 дижитал хичээл, 111 видео, 2 гарын авлага, 11 төрлийн онлайн хичээлийг монгол хэлээр байршуулж, нийт ерөнхий боловсролын сургуулийн суралцагч сургалтад, үнэ төлбөргүй ашиглаж эхлээд байна.

Тав. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын нийгмийн сүлжээ ашиглалтын талаарх судалгаа, цахим гэмт хэрэг, зөрчил, цахим дээрэлхэлт, гадуурхалтын хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн болон цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний тухайд

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран 2025 онд Улаанбаатар хотын 12 төрийн болон хувийн сургуулийн нийт 5,477 оролцогчийг хамрагдсан "Монголын хүүхэд, өсвөр үеийнхний дундах цахим дээрэлхэлтийн талаарх судалгаа" хийсэн. Уг судалгаагаар 9–12 насны хүүхдүүдийн ойролцоогоор гуравны нэг нь, харин 13–17 насны өсвөр үеийнхний 51.3 хувь нь доромжлол, зарим тохиолдолд цахим дээрэлхэлтийн улмаас бэлгийн дарамтад өртөж хохирогч болж байгаа, цахим дээрэлхэлтэд өртсөн хүүхдүүдийн тал орчим хувь нь энэ тухайгаа хэн нэгэнд мэдэгддэггүй нь судалгаагаар тогтоогдсон.

Боловсролын яамнаас санаачлан Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газарт хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Ерөнхий боловсролын сургуульд түшиглэсэн олон нийтийн цахим мэдээллийн ажилтан (цаашид "ОНЦМА" гэх) болон өсвөрийн цахим манлайлагчдыг бэлтгэж, тэдний тусламжтай сургуулийн интернэт холболтын чанар болон үүнтэй холбоотой тоон мэдээллийг цуглуулах, мөн тухай орон нутгийн иргэдийн суурь цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой "Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх туршилтын төсөл"-ийг хэрэгжүүлсэн.

Цахим орчинд аюулгүй байдлаа хангах, сургуулийн интернэтийн сүлжээний талаар суурь ойлголт, цахимаар суралцах сургалтын Pearson, Eduten зэрэг боловсролын сургалтын зориулалттай платформын ач холбогдлыг таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх, үе тэнгийн сурагчдад зөвлөгөө мэдээлэл өгөх, цахим систем ашиглахад тулгамдаж буй асуудал бэрхшээлийг илрүүлэх, туслалцаа үзүүлэх, орон нутгийн иргэдэд төрийн цахим үйлчилгээг хэрхэн ашиглах талаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, мэдээлэл өгөх, иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой ОНЦМА (Олон Нийтийн Цахим Мэдээллийн Ажилтан) болон өсвөрийн цахим манлайлагчийг чадавхжуулах зэрэг 23 агуулга бүхий сургалтыг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуульд түшиглэсэн олон нийтийн цахим

мэдээллийн ажилтан бэлтгэх, тогтмол ажиллах цахим ур чадвартай 70 ОНЦМА багш, 10 боловсролын газрын мэргэжилтэн, 350 өсвөрийн цахим манлайлагч хүүхэд тус тус бэлтгэгдсэн. Эдгээр сургагч багш, цахим манлайлагч хүүхдүүдийн зохион байгуулсан сургалтад 700 орчим сурагч, 3204 иргэн хамрагдлаа.

Мөн “ЧИМЭЭГҮЙ ИТГЭЛ” нээлттэй суваг ажиллуулах бэлтгэл ажлын хүрээнд 12,682.542 цахим хэрэглэгчдэд ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн видео контент, зурган постер, мэдээллийг цахим орчинд түгээн сурталчилсан.

Суралцагчдыг аливаа эрсдэл, хорт зуршил, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр 16 төрлийн постер, зөвлөмж, 6 видеог байгууллагын пэйж, цахим хуудас, нийслэлийн 9 дүүргийн Боловсролын хэлтэс, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн цахим хуудсаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш, суралцагчдад болон 385 нийгмийн ажилтанд хүргэж ажилласан.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд “Үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх”, “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр сургалт зохион байгуулж, 28,787 оролцогч хамрагдан мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлсэн.

2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 900 сургуулиас 655 буюу 91.3 хувь нь дотоод сүлжээтэй, 527 дотуур байрны 253 буюу 51.4 хувь интернэтэд холбогдсон, 94 буюу 19.1 хувь нь дотоод сүлжээнд холбогдсон байна.

Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд ашиглаж буй интернэт сүлжээнд Facebook, Youtube-ээс бусад Instagram, TikTok, www.blizzard.com зэрэг олон нийтийн сүлжээний платформ болон 18+ контентын шүүлтүүртэй байх, цахим орчин дахь хүүхэд хамгааллын механизм (MAC хаяг, шүүлтүүр, галт хана, насны баталгаажуулалт, цагийн хязгаарлалт, хортой контент, зар сурталчилгааг хаах) нэвтрүүлэх, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг найдвартай, интернэт сүлжээнд холбох, улмаар хэрэглэгчийн ашиглаж буй интернэт холболтын чанарыг бодит цагийн горимоор хянах талаар үүрэн телефоны операторуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих, багш, ажилтан цахим орчинд нөхөрсөг бус харилцсан суралцагчдын хооронд үүссэн маргааныг зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хамтарч ажиллахтай холбоотой харилцааг дараах дүрэм, журамд тусган хэрэгжүүлж байна.

Боловсролын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.2.8-т хүүхдийн эрхийн зөрчил, үе тэнгийн дээрэлхэлт, дарамт, ялгаварлан гадуурхалт, гэмт хэрэг, хорт зуршил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээ, аюулгүй байдлаа хангах талаар суралцагчдыг соён гэгээрүүлэх, чадавхжуулах, оролцоог хангах олон талт арга хэмжээ зохион байгуулахаар заасан бол мөн 3.5-д сургууль нь сургалт, үйл ажиллагаа зохион

байгуулах, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангах, суралцагчийн мөрдөх ёс суртахууны хэм хэмжээ тогтоох, багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон олон нийтээс санал, гомдол, мэдээлэл хүлээн авах, хянан шийдвэрлэх, хариу өгөх, цахим орчны зохистой хэрэглээг зохицуулахад холбоотой дүрэм, журмыг баталж мөрдөхөөр журамласан.

Тус журмын 5.6-д “Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь гэр-сургууль, сургууль-гэр хоорондын аюулгүй байдал болон хичээлийн бус цагаар хүүхдийнхээ аюулгүй байдлыг бүрэн хариуцах, цахим хэрэгсэл, сүлжээний зөв зохистой хэрэглээний талаар үлгэрлэх, хяналт тавих, хүүхдийнхээ сонирхол хэрэгцээнд нийцсэн хөгжлийн үйлчилгээнд хамруулах, тэдний нас, хөгжлийн онцлог, хүсэл сонирхол, зан төлөв, сурлага, эрүүл мэндийн талаар багш, холбогдох ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллахаар тусгасан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын хүрээнд “ХҮҮХДЭД АЮУЛГҮЙ ЦАХИМ ОРЧИН” аяныг эхлүүлж, “Монгол нэт” цахим харилцааны платформыг 28 сургуульд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зургаа. Дээрх асуудлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнчлэн гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургах асуудлаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухайд

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээж, ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхээр заасан.

2025-2026 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 2175, ерөнхий боловсролд 6735, мэргэжлийн болон техникийн боловсролд 633, их дээд сургуульд 347, насан туршийн суралцахуйн төвд 392, дэмжих үйлчилгээнд 125, нийт 10,407 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

Боловсролын сайдын 2024 оны А/81 дүгээр тушаалаар цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам, 2025 оны А/294 дүгээр тушаалаар ганцаарчилсан сургалт зохион байгуулах аргачлалыг тус тус батлан хэрэгжүүлэв. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан танхимын сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд дэмжих үйлчилгээг туршин хэрэгжүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн

дүрэм"-ийг Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж эхэлснээр хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 111 хүүхдийг боловсролд нэмж хамруулав. Үүний үр дүнд 2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 6735 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хамрагдсан нь хүрэх түвшнээс 0,6 хувийг давж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролд хамрагдалт 80 хувьд хүрсэн.

Мэдлэ цахим сургуульд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйд дэмжлэг үзүүлэх зорилгоор хэл засал, дохионы хэлний цахим анги нээхээр цахим сургалт зохион байгуулах багшийг бэлтгэж, багш, эцэг эх/асран хамгаалагч, хүүхдээс авах гурван төрлийн асуулгыг боловсруулан Google Form -оор болон цахим хуудаст постер байршуулан судалгаа авч, 2026 онд цахим сургалтыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Түүнчлэн Боловсролын яам, Люксембургийн вант улсын Гадаад Хэргийн Яамтай хамтран хэрэгжүүлж буй "Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт тэгш хамран сургах боловсрол олгох онлайн платформ бий болгох нь" төслийн хүрээнд Мэдлэ цахим сургуультай хамтран дохионы хэлний анхан, дунд шатны цахим сургалтын платформыг хөгжүүлсэн.

Багш, сурагчид, эцэг эхчүүдэд зориулсан дохионы хэлний цахим сургалтын санг хөгжүүлэх зорилгоор Дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох 20 видео хичээлийг Багш-Эцэг эхийн холбоо бүтээж, <https://adina.org.mn> вэб сайтын сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн онлайн модульд байршуулсан.

Medle.mn сургалтын платформд байршуулсан нийт 3254 теле хичээлийг дохионы хэлмэрчтэй хамтран сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамрагдан сурах боломжтойгоор тохируулга хийгдсэн. Ингэснээр сонсголын бэрхшээлтэй суралцагчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран үндэсний сургалтын хөтөлбөрт нийцсэн чанартай контентыг дохионы хэлээр хүлээн авч, бие даан суралцах боломж бүрдсэн. Мөн аудио хайлтын систем нэмэгдсэн нь бичихэд хүндрэлтэй эсвэл харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд хайж буй хичээлээ хялбар олоход туслах боломжтой болж систем ашиглах боломж нээгдсэн. Хичээлийн хоцрогдол арилгах: Эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ хамт хичээлээ үзэж, агуулгыг бататгах, хоцрогдол арилгах боломжтой болсон. Бие даан суралцах: Системд нэвтэрснээр өөрийн үзэж буй хичээлийн явцыг хянах, өөрийгөө сорих боломжтой болсон нь суралцагчийн бие даан суралцах идэвхийг нэмэгдүүлж байна.

Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд "Нийгэм ахуйн баримжаа" хичээлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинээр боловсруулж, баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн ном, сурагчийн дасгал ажлын дэвтрийг хэвлэн 2026-2027 оны хичээлийн жилээс хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мэдлэ цахим сургууль ахлах ангийн сонгон судлах хөтөлбөрийг 2022 оноос Монгол Улсад байгаа болон хилийн чанадад байгаа сурагчдад 350 багш хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт 17,000 хүүхэд хамрагдаж байна. Багш нар мөн хилийн чанадад болон Монгол Улсын өнцөг булан бүрээс цахимаар ажилладаг бөгөөд давхардсан

тоогоор гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат 56 хүүхэд тус хөтөлбөрт хамрагдаж байна.

